

УЛСЫН ИХ ХУРАЛ
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот
2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “16¹.5.3. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”, “7.1.3. Төсвийн тусгай шаардлагыг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлах үйл ажиллагаанд баримтална” гэсэн заалтуудыг үндэслэн дүгнэлт гаргав.

Зөвлөл дүгнэлт гаргахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасны дагуу тайлагнагдсан эсэхэд анхаарсан болно.

1. “Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-д дурдсанаар 5,559 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит 638 хуулийн этгээд, 370 төрийн сан, 349 төсөл, сан болон Төв төрийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан зэрэг нийт 6,916 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Өмнөх онтой харьцуулахад төсөвт байгууллагын тоо 117, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 19, төсөл, сан 54-ээр тус тус нэмэгдэж, нийт санхүүгийн тайлагналт гаргасан байгууллагуудын тоо 190 болж өссөн байна. Засгийн газрын байгууллагууд тэр дундаа төсвийн байгууллагуудын тоо, төсөл, сангуудын тоо нэмэгдэж байгаа нь хүн амын өсөлт болон төрийн үйлчилгээний хамрах хүрээ ихсэж байгаатай холбоотой боловч Засгийн газрын хэт нүсэр болон данхгар төрийг бий болгож байгааг анхаарч аль болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хууль сахиулах салбар, онцгой байдлаас бусад салбарын байгууллагуудын тоог нэмэхээс зайлсхийх шаардлагатай. Нэг байгууллага нэмэгдэх нь дарга, ажилтнууд болон тэдгээртэй холбоотой төсвийн болон төрийн байгууллагуудын урсгал зардал нэмэгдэх гол шалтгаан болж байна.

2. Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаар нийт хөрөнгө болон өр, төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 122,238.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 15,527.6 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар, харин 2022 онтой харьцуулахад 29,258.5 тэрбум төгрөг буюу 29.4 хувиар нэмэгджээ. Нийт хөрөнгө ийнхүү нэмэгдсэн нь 2023 оноос эргэлтийн хөрөнгө 9,953.6 тэрбум төгрөг буюу 25.3%, эргэлтийн бус хөрөнгө 5,573.9 тэрбум төгрөг буюу 8.3%-аар, харин 2022 оноос эргэлтийн хөрөнгө 20,287.0 тэрбум төгрөг буюу 60.8%, эргэлтийн бус хөрөнгө 8,971.5 тэрбум төгрөг буюу 13.6%-аар өссөнтэй холбоотой.

Хүснэгт 1. Засгийн газрын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хийсэн шинжилгээ, тэрбум төгрөг, хувь

Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	2023-2022	2024-2023	2023/2022	2024/2023
Эргэлтийн хөрөнгө	29,085.9	39,419.3	49,372.9	10,333.3	9,953.7	135.5	125.3
Эргэлтийн бус хөрөнгө	63,893.6	67,291.2	72,865.1	3,397.6	5,573.9	105.3	108.3
НИЙТ ХӨРӨНГӨ	92,979.5	106,710.5	122,238.1	13,731.0	15,527.6	114.8	114.6
Нийт өр төлбөр	53,194.7	55,194.2	57,724.0	1,999.5	2,529.8	103.8	104.6
Цэвэр хөрөнгө, өмч	39,784.8	51,516.3	64,514.1	11,731.5	12,997.7	129.5	125.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ	92,979.5	106,710.5	122,238.1	13,731.0	15,527.6	114.8	114.6

Түүнчлэн цэвэр хөрөнгө, өмчийн дүн өмнөх оноос 12,997.7 тэрбум төгрөг буюу 25.2%, нийт өр төлбөр 2,529.8 тэрбум төгрөг буюу 4.6%-аар, 2022 оноос цэвэр хөрөнгө, өмчийн дүн (Засгийн газрын хувь оролцоо) 24,729.2 тэрбум төгрөг буюу 62.2%, нийт өр төлбөр 4,529.3 тэрбум төгрөг буюу 8.5%-аар тус тус нэмэгдсэн байна.

- Засгийн газрын нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгө 2022 онд 31.3 хувь, 2023 онд 36.9 хувь, 2024 онд 40.4 хувийг эзэлж, жил бүр эзлэх хувь нь нэмэгдсэн бол эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь сүүлийн 3 жилд буурах хандлагатай болжээ.

Хүснэгт 2. Засгийн газрын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хийсэн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, дүнд эзлэх хувиар

Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Бүтцийн шинжилгээ		
				2022	2023	2024
Эргэлтийн хөрөнгө	29,085.9	39,419.3	49,372.9	31.3	36.9	40.4
Эргэлтийн бус хөрөнгө	63,893.6	67,291.2	72,865.1	68.7	63.1	59.6
НИЙТ ХӨРӨНГӨ	92,979.5	106,710.5	122,238.1	100.0	100.0	100.0
Нийт өр төлбөр	53,194.7	55,194.2	57,724.0	57.2	51.7	47.2
Цэвэр хөрөнгө, өмч	39,784.8	51,516.3	64,514.1	42.8	48.3	52.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ	92,979.5	106,710.5	122,238.1	100.0	100.0	100.0

Харин өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн дүнд нийт өр төлбөр жилээс жилд буурч, цэвэр хөрөнгө буюу Засгийн газрын хувь оролцоо 2022 онд 42.8 хувь байсан бол 2023 онд 48.3 хувийг эзэлж, 2024 онд 52.8 хувь болж өссөн байна. Энэ нь *өрийн харьцаа* багасаж, *цэвэр хөрөнгийн харьцаа* сайжирч буйг илтгэх зохистой хандлага гэж үзэж байна.

- “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан”-гаар үйл ажиллагааны нийт үр дүн 17,336.7 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй, өмнөх 2023 оноос 6,177.5 тэрбум төгрөгөөр буюу 35.6 хувиар илүү хуримтлагдсан үр дүнтэй гарчээ.

Хүснэгт 3. Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд хийсэн шинжилгээ, тэрбум төгрөг, хувь

Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Харьцуулсан шинжилгээ			
				2023-2022	2024-2023	2023/2022	2024/2023
Үйл ажиллагааны орлого	31,213.3	42,806.6	56,004.7	11,593.3	13,198.1	37.1	23.6
Татварын орлого	16,959.5	22,517.7	28,609.9	5,558.2	6,092.2	32.8	21.3
Татварын бус орлого	13,771.8	20,107.5	26,801.3	6,335.6	6,693.9	46.0	25.0
Тусламж, санхүүжилтийн орлого	482.0	181.5	593.5	(300.5)	412.0	-	69.4
Үйл ажиллагааны зардал	22,393.8	28,870.9	35,164.3	6,477.1	6,293.4	28.9	17.9

Урсгал зардал	22,368.9	28,828.5	35,088.3	6,459.5	6,259.8	28.9	17.8
Хөрөнгийн зардал	24.9	42.4	76.0	17.5	33.5	70.5	44.2
Үйл ажиллагааны үр дүн	8,819.5	13,935.7	20,840.5	5,116.2	6,904.7	58.0	33.1
Үйл ажиллагааны бус орлого	5,577.7	5,563.1	6,833.8	(14.6)	1,270.7	(0.3)	18.6
Үйл ажиллагааны бус зардал	12,280.7	8,339.7	10,337.6	(3,941.1)	1,997.9	(32.1)	19.3
Үйл ажиллагааны нийт үр дүн	2,116.4	11,159.2	17,336.7	9,042.8	6,177.5	427.3	35.6

Үйл ажиллагааны нийт үр дүн ийнхүү нэмэгдэхэд татварын болон татварын бус орлого, түүнчлэн үйл ажиллагааны бус орлого, хөрөнгийн зардал, үйл ажиллагааны бус зардлын өсөлт голлон нөлөөлжээ. Түүнчлэн Засгийн газрын 2022-2024 оны үйл ажиллагааны орлого, зарлагын бүтцийг шинжилж үзэхэд үйл ажиллагааны орлогод татварын орлогын эзлэх хувь 2022 онд 54.3 хувь байсан бол 2023, 2024 онд буурч 51.1 хувьд хүрсэн байна. Үүний дотор ХХОАТ, ААНОАТ зэрэг орлогын албан татварын эзлэх хувь 12.3 хувиас 16.3 хувь болж өссөн бол НӨАТ-ын эзлэх хувь 12.6 хувиас 10.4 хувь хүртэл буурчээ. Татварын бус орлогод нийтлэг татварын бус орлого өндөр хувийг буюу 42.7-46.5 хувийг эзэлдэг болсон байна.

Хавсралт 4. Засгийн газрын 2022-2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь үйл ажиллагааны орлого, зарлагад хийсэн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, дүнд эзлэх хувиар

Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Бүтцийн шинжилгээ		
				2022	2023	2024
Үйл ажиллагааны орлого	31,213.3	42,806.6	56,004.7	100.0	100.0	100.0
<i>Татварын орлого</i>	<i>16,959.5</i>	<i>22,517.7</i>	<i>28,609.9</i>	<i>54.3</i>	<i>52.6</i>	<i>51.1</i>
Орлогын албан татвар	3,847.3	5,928.7	9,114.9	12.3	13.9	16.3
НӨАТ	3,946.2	4,791.4	5,843.6	12.6	11.2	10.4
<i>Татварын бус орлого</i>	<i>13,771.8</i>	<i>20,107.5</i>	<i>26,801.3</i>	<i>44.1</i>	<i>47.0</i>	<i>47.9</i>
Нийтлэг татварын бус орлого	13,336.4	19,712.1	26,054.4	42.7	46.0	46.5
<i>Тусламж, санхүүжилтийн орлого</i>	<i>482.0</i>	<i>181.5</i>	<i>593.5</i>	<i>1.5</i>	<i>0.4</i>	<i>1.1</i>
Үйл ажиллагааны зардал	22,393.8	28,870.9	35,164.3	100.0	100.0	100.0
<i>Урсгал зардал</i>	<i>22,368.9</i>	<i>28,828.5</i>	<i>35,088.3</i>	<i>99.9</i>	<i>99.9</i>	<i>99.8</i>
<i>Бараа, ажил үйлчилгээний зардал</i>	<i>15,331.8</i>	<i>19,267.9</i>	<i>23,707.9</i>	<i>68.5</i>	<i>66.7</i>	<i>67.4</i>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,721.1	4,981.1	7,077.3	16.6	17.3	20.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,126.4	8,450.2	9,239.3	22.9	29.3	26.3
<i>Урсгал ишлэжүүлэг</i>	<i>4,821.2</i>	<i>7,273.2</i>	<i>8,789.3</i>	<i>21.5</i>	<i>25.2</i>	<i>25.0</i>
<i>Хөрөнгийн зардал</i>	<i>24.9</i>	<i>42.4</i>	<i>76.0</i>	<i>0.1</i>	<i>0.1</i>	<i>0.2</i>

Сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны зардал үндсэндээ урсгал зардалтайгаа тэнцүү байгаа бөгөөд уг зардлын 2/3-ыг бараа, үйлчилгээний зардал эзэлж байна. Үүний дотор 2022, 2023, 2024 онд “Цалин хөлс, нэмэгдэл урамшил” харгалзан 16.6%; 17.3%; 20.1% болж эзлэх хувь нь нэмэгдэж буй хэдий ч “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” харгалзан 22.9%; 29.3%; 26.3%-ийг эзэлж, урсгал зардалд хамгийн

өндөр хувьтай зардал болжээ. Урсгал шилжүүлгийн зардал ч 21.5-25.0 хувийг эзэлж байгаад анхаарал хандуулах шаардлагатай юм.

5. “Засгийн газрын 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан”-гаар Засгийн газрын хувь оролцоо 2023 онд 2022 оноос 11,731.5 тэрбум төгрөгөөр, 2024 онд 2023 оноос 12,997.7 тэрбум төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 2023 онд 11,167.8 тэрбум төгрөг, 2024 онд 17,336.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Засгийн газрын хувь оролцооны хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн нь эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлоготой уялдахгүй байгааг анхаарч, төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардал хийдлийг арилгах, нэгтгэх, бүтцийн өөрчлөлт, зохион байгуулалт хийх, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар санал болгож арилжаалах ажлыг эрчимжүүлэн, яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй.

6. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн “2.4. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан”-аас харахад үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн өмнөх оноос 25,336.0 тэрбум төгрөг буюу 46.27 хувиар нэмэгдэж, 80,088.2 тэрбум төгрөг болсон байна. Ингэж нэмэгдэхэд голлон нөлөөлсөн орлого нь ХХОАТ 741.4 тэрбум төгрөг буюу 39.3 хувиар, ААНОАТ 2,455.2 тэрбум төгрөг буюу 59.8 хувиар, НДШ-ийн орлого 64.6 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар, НӨАТ-ын орлого 1,083.9 тэрбум төгрөг буюу 22.7 хувиар, Онцгой албан татвар 308.8 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар, нийтлэг татварын бус орлого 19,347.0 тэрбум төгрөг буюу 62.05 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Эндээс үзэхэд Засгийн газрын үйл ажиллагааны мөнгөн орлого нэмэгдэхэд нийтлэг бус татварын орлого голлон нөлөөлсөн байна. Татварын орлогууд нэмэгдэхээс илүүтэй “Нийтлэг бус татварын орлого” нэмэгдсэн байгаад анхаарах шаардлагатай байна.

7. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн “2.4. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан” дахь нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх онтой харьцуулахад 27,213.5 тэрбум төгрөг буюу 68.12 хувиар нэмэгджээ. Энэ өсөлтийн дийлэнх хэсэг буюу 25,171.6 тэрбум төгрөг нь “Бараа, ажил үйлчилгээний зардал” байна. Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн зардал нь “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал” бөгөөд өмнөх онд 13,769.9 тэрбум төгрөг байсан бол тайлант онд 20,620.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 34,390.1 тэрбум төгрөг болжээ. Улсын нэгдсэн төсвийн урсгал зарлагад эзлэх “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж”-ийн дүн 2024 онд 1,422.1 тэрбум төгрөг байсан. Харин үлдэх 32,968.0 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд, төсөл, санд ногдож байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Төрийн болон орон нутгийн хуулийн этгээдүүд болон төсөл, сангийн “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж”-ийн зардал нь Улсын нэгдсэн төсвийн нэг жилийн зарлагатай тэнцэх хэмжээний хөрөнгө болж байгаа нь энэ зардлын ангиллын хүрээнд маш их хэмжээний хөрөнгө зарцуулагдаж байгааг харуулж байна. Түүнчлэн “Бараа үйлчилгээний бусад зардал” өмнөх онтой харьцуулахад 1 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Цаашид энэхүү зардлын ангиллын хүрээнд зарцуулагдах хөрөнгийн хүрээ, хязгаар, дэд ангиллыг тодорхой болгох, ялангуяа “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж” гэсэн зардлын ангиллыг тодорхой болгох шаардлагатай байна.

8. Засгийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14,545.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2,454.8 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнээс “банканд байгаа бэлэн мөнгө” 12,127.9 тэрбум төгрөг байгаа нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 83.4% болж байна. Үүнээс төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийнх 5,290.5 тэрбум төгрөг, төрийн санд 2,982.3 тэрбум төгрөг, төсөл/сангуудад 5,525.7 тэрбум төгрөг байна. Төсвийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн арилжааны банканд хадгаламж хэлбэртэй байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2024 онд өмнөх оноос 1,802.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2,007.5 тэрбум төгрөг болсон байна. Гэтэл Засгийн газар, Сангийн яам төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаасны дүн 303.4 тэрбум төгрөг¹ болж, түүний хүүгийн зардалд 7.5 тэрбум төгрөг зарцуулжээ.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Арилжааны банканд хадгаламж хэлбэртэй байршиж байгаа энэхүү 2 их наяд төгрөг бий болсон үндэслэл шалтгааныг тодруулах шаардлагатай бөгөөд цаашид Засгийн газар дотооддоо урт болон богино хугацаатай нэрлэсэн хүүтэй Засгийн газрын үнэт цаас гаргахаас илүүтэй Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах замаар арилжааны банкнуудад хадгаламж хэлбэртэй байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг үр ашигтай ашиглахад анхаарал хандуулах нь зүйтэй. Өмнөх жилийн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Зөвлөлөөс өгсөн дүгнэлтэд энэ талаар дурдаж байсан болно.

9. Засгийн газрын байгууллагуудын банкны Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2024 оны эцэст 2,007.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,802.4 тэрбум төгрөгөөр буюу 9.7 дахин өссөн байна.² Энэ дүн нь Улсын нэгдсэн төсвийн 2024 оны нийт зарлагын гүйцэтгэл болох 30,451.1 тэрбум төгрөгийн 6.5 хувьтай тэнцэж байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Төсвийн байгууллагууд, төсөвт аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн байгууллагууд, Төрийн өмчит хуулийн этгээдүүд, сан, банк, Их, дээд сургуулиуд (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, МУИС, МУБИС, ШУТИС, АУШИС, Хөгжийн банк зэрэг)-ийн банкин дахь хадгаламжийн үлдэгдэл өмнөх онд ч байсан бөгөөд энэ онд бас ийм үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын бэлэн мөнгөний удирдлага хангалтгүйг харуулах төдийгүй тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, шинж чанараас хамаарч байгаа нь үнэн юм. Гэвч энэ үлдэгдэл арилжааны банкнуудын зээлийн хөрөнгийн эх үүсвэр болж байгааг таслан зогсоож, тодорхой хэмжээгээр Сангийн яамны Төв төрийн сантай хийх гэрээний үндсэн дээр хөрөнгийн менежментээр зохицуулж байх боломжтой гэж үзэж байна.

10. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 863.6 тэрбум төгрөгөөр буурч, тайлант онд 909.7 тэрбум төгрөг болжээ³.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Аудитын тайлангаар илэрсэн зөрчлүүд болох “Чингис хаан”, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк”-уудад байршиж байгаа 256.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэнийг анхаарч, буруутай

¹ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 31-р хуудас

² Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 14-р хуудас, Хүснэгт №3.

³ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 14-р хуудас.

этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ авч, Монголбанктай хамтран төрийн санд татан төвлөрүүлэх шаардлагатай болсон байна. Мөн өмнөх онуудад хэрэгжээгүй нийт 1,787.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилтийн барьцаа хөрөнгө болох 726.1 тэрбум төгрөгийг чөлөөлж, улсын төсвийн орлогод буцаан авах, цаашид төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй байхад санхүүжилтийг байршуулдаг асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах, төсвийн сахилга бат, хяналтыг сайжруулах шаардлага үүссэн байна.

11. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,430.8 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 156.2 тэрбум төгрөг тус тус болсон гэж тайлагнажээ.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Монголбанк болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагатай хамтран Чингис хаан банк дахь авлагыг бүрэн шийдвэрлэх, цаашид ийм төрлийн зөрчил гаргахгүй байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

12. Улсын болон орон нутгийн төсвийн захирагчид нь /ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд/ жилийн эцсийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээ тайлагнадаггүй, зөрүүтэй тайлагнасан, тайланд нэгтгүүлдэггүй, төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлдэггүй, зориулалтын бус зүйлд үр ашиггүй зарцуулсан, ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгодог, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгодог, татвар суутгаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч зарлагын гүйгээг хийдэг, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд төсвийн хөрөнгийг байршуулах, мөнгөн хөрөнгийг төрийн дансанд төвлөрүүлээгүй, арилжааны банкаар гүйлгээ хийсэн, батлагдсан төсвөөс харьяа байгууллагын зардлыг санхүүжүүлсэн зэрэг 541.9 тэрбум төгрөгийн зөрчил аудитын шалгалтаар илэрсэн байна⁴.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Энэ нь төсвийн сахилга бат, хариуцлага суларч, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зарчмууд алдагдаж байгааг Үндэсний аудитын газрын дүгнэлт харуулж байна. Эдгээр зөрчил нь өмнөх жилүүдийн аудитын тайлангаар байнга давтагдан гардаг бөгөөд тус Зөвлөлөөс өмнөх жилд адил дүгнэлт өгч анхааруулж байсан болно. Иймд төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн хөрөнгийг үр ашигтай ашиглах, төсвийн хууль, тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах бодит шаардлага бий болж, Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль зэрэг хууль, тогтоомжуудад энэ талын харилцааг шинээр авч үзэж, шинэчлэн тусгах шаардлагатай байна.

13. Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангаас үзэхэд⁵ төсөвт байгууллагуудын авлага 728.9 тэрбум төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага 3,101.7 тэрбум төгрөг, төрийн сангийн авлага 1,435.2 тэрбум төгрөг, төсөл, сангийн авлага 1,545.8 тэрбум төгрөг тус тус болж, нийт

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 17-р хуудас.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 21-23-р хуудас.

авлагын дүн 6,811.7 тэрбум буюу төсвийн нийт зарлагын 21.6%-тай тэнцэж байна. Мөн нийгмийн даатгалын сангийн авлага 726.7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн авлага 168.8 тэрбум төгрөг тус тус болжээ.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Авлага өндөр байгаа нь Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, салбарын яамд төсөв, төрийн өмчийн хөрөнгийг зохистой удирдаж чадахгүй байгаагийн илрэл бөгөөд цаашид эдгээр байгууллагын тухайн оны төсвийн санхүүжилтийг авлагатай нь уялдуулан олгодог байх арга хэмжээг авах нь чухал болжээ. Цаашид үүнд илүүтэй анхаарч энэ авлагыг 2025 онд бүрэн багтаан барагдуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх, тодорхой хугацаатай даалгавар, чиглэл өгөх хэрэгтэй байна.

14. Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангаас харахад нийт өр төлбөрийн үлдэгдэл 57,724.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2,529.8 тэрбум төгрөгөөр өсжээ. Өр төлбөрийн нийт дүнд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр 22,074.7 тэрбум төгрөг, төрийн сангийн өр 33,784.9 тэрбум төгрөг, төсөвт байгууллагуудын өр 1,322.5 тэрбум төгрөг, төсөл, сангуудын өр 541.9 тэрбум төгрөг тус тус болжээ. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 32,021.5 тэрбум төгрөг гэж үзвэл дотоод өр 25,702.5 тэрбум төгрөг болсон байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Цаашид 2015 оны 2 дугаар сарын 15-ны өдөр УИХ-аар батлагдсан “Өрийн удирдлагын тухай” хуульд тодорхой нэмэлт өөрчлөлт хийж, “Улсын секторын өр” гэсэн тодорхойлолтыг авч үзэн, түүнд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын өрийг хамруулдаг байх, Өрийн удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйл буюу Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож, зөрчил гаргасан төрийн албан хаагчдад ногдуулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх нь чухал.

15. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн тайланд тусгагдсан Засгийн газрын өмч, хөрөнгийн тайлангийн мэдээллээс үзвэл цэвэр хөрөнгө өмчийн дүн 64,514.1 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 80.6%-тай тэнцэж байна. Тайланд тусгагдсан төрийн өмчит үйлдвэрийн газруудын өмч хөрөнгийн дүн 44,777.7 тэрбум төгрөг болж ДНБ-ий 56.0%-ийг эзэлж байна. Мөнгөн дүнгээр ийнхүү илэрхийлэгдэж байгаагийн зэрэгцээ төсвийн байгууллагууд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хүрээнд огт ашиглалтгүй орхигдож байгаа барилга, объект олон байгаа нь хөдөө орон нутагт цөөнгүй байгаа юм.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Төсвийн Байнгын хороо, Төсвийн Зарлагын хяналтын дэд хорооны зүгээс энэ асуудалд анхаарал хандуулж, ТЭЗ тус бүрийн санхүүгийн тайлан, төрийн өмч, хөрөнгийн ашиглалтын асуудлыг нарийвчлан нягтлан шалгаж, төрийн бүтээмжийг сайжруулах талаас дүгнэлт хийх шаардлагатай гэж үзэж байна.

16. Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагатай холбоотой барагдаагүй авлагын үлдэгдэл 492.4 тэрбум төгрөг, эргэн төлөгдөх нөхцөлтэй боловч өглөгөөр хүлээн зөвшөөрөгдөөгүй болон хугацаа хэтэрсэн нийт 148.5 тэрбум төгрөг, тайлан бүртгэлд тусгагдаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, эргэн төлөлт хийгдээгүй нийт 44.5 тэрбум төгрөг байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Засгийн газрын гадаад, дотоод зээл, түүнтэй холбоотой 1991-1994, 1991-1996 онуудын зээлийн авлагын асуудлыг нэн даруй эцэслэн шийдвэрлэж, гадаад зээлийг дамжуулан зээлдүүлсэн гэрээний авлагыг барагдуулах, улсыг хохиролгүй болгох зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй болжээ⁶.

17. Засгийн газрын болон Төсвийн захирагчид (ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд)-ын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар нийт 15,719.9⁷ тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Энэхүү алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 7,582.5 тэрбум төгрөгөөр буюу 93.2 хувиар өсжээ.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Нийт илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 50 орчим хувьтай тэнцэж байгаа бөгөөд Засгийн газрын байгууллагуудын хувьд буюу нийт төсвийн захирагчид төсөв, санхүүгийн хууль, тогтоомжийг мөрддөггүйгээс гадна төсөв, санхүүгийн сахилга бат алдагдсан байгааг илтгэх томоохон баримт мөн. Цаашид төсөв, санхүүгийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах шаардлагатай байна.

18. “Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-д дурдсанаар⁸ нийт 6,832 төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөр нэгж хамрагдахаас 3,486 санхүүгийн тайланд нь аудитын дүгнэлт гаргажээ. Аудитын дүгнэлтээр санхүүгийн тайланд хийгдсэн аудитын 18.9% нь буюу 659 санхүүгийн тайлан нь “хязгаарлалттай”, 0.7% нь буюу 25 санхүүгийн тайлан нь “сөрөг” дүгнэлттэй гарсан байна. Мөн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчдын 9 нь буюу 41% нь “Хязгаарлалттай” болон 1 нь буюу 4.5% нь “Сөрөг” гэсэн дүгнэлт авчээ. Өөрөөр хэлбэл, аудитад хамрагдсан байгууллагуудын 1/5 нь ямар нэг байдлаар “Хязгаарлалттай” болон “Сөрөг” дүгнэлт авсан нь төсөв, санхүүгийн сахилга бат алдагдах, түүнд тавих хяналт шалгалт, хариуцлага илтэд суларсныг харуулж байна.

Бодлогын дүгнэлт, зөвлөмж: Үндэсний аудитын газраас Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт болох “Хязгаарлалттай” гэсэн санал, дүгнэлттэй Төсвийн тогтвортой байдлын Зөвлөл санал нэг байгаа бөгөөд УИХ-аас Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан Засгийн газарт төрийн болон төсвийн сахилга батыг сайжруулах, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг ил тод, нээлттэй байдлаар авч хэрэгжүүлэх агуулга бүхий тодорхой үүрэг, чиглэл, даалгавар бүхий тусгайлан тогтоол гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 20-р хуудас.

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 35-р хуудас.

⁸ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. 35-р хуудас.

Хавсралт 1. Засгийн газрын 2022-2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хийсэн харьцуулсан шинжилгээ, тэрбум төгрөг, хувиар

Код	Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Харьцуулсан шинжилгээ			
					2023-2022	2024-2023	2023/2022	2024/2023
1	Эргэлтийн хөрөнгө	29,085.9	39,419.3	49,372.9	10,333.3	9,953.7	135.5	125.3
31	Мөнгөн хөрөнгө	6,636.7	12,090.9	14,545.8	5,454.3	2,454.9	182.2	120.3
32	Богино хугацаат хөрөнгө оруулалт	451.5	418.9	1,842.3	(32.6)	1,423.4	92.8	439.8
33	Авлага	6,333.8	6,445.2	6,811.7	111.4	366.5	101.8	105.7
34	Урьдчилгаа	3,614.5	5,137.6	5,891.6	1,523.1	753.9	142.1	114.7
35	Бараа материал	3,274.6	3,652.0	4,262.4	377.4	610.5	111.5	116.7
36	Нөөцийн бараа	210.6	210.1	262.2	(0.6)	52.2	99.7	124.8
360	Бусад эргэлтийн хөрөнгө	8,564.2	11,464.6	15,756.9	2,900.4	4,292.3	133.9	137.4
2	Эргэлтийн бус хөрөнгө	63,893.6	67,291.2	72,865.1	3,397.6	5,573.9	105.3	108.3
37	Урт хугацаат хөрөнгө оруулалт	11,558.5	11,769.9	13,292.0	211.4	1,522.1	101.8	112.9
37100	Урт хугацаат хадгаламж	56.9	60.0	58.0	3.1	(2.0)	105.5	96.6
37200	Үнэт цаас	3,506.3	3,270.0	2,660.0	(236.3)	(610.0)	93.3	81.3
37300	Урт хугацаат зээл	7,995.3	8,439.8	10,574.1	444.5	2,134.2	105.6	125.3
39	Үндсэн хөрөнгө	52,335.1	55,521.4	59,573.1	3,186.3	4,051.8	106.1	107.3
39100	Газар	59.8	46.0	46.1	(13.9)	0.1	76.8	100.3
39200	Биет хөрөнгө	27,443.2	29,965.0	34,670.4	2,521.8	4,705.4	109.2	115.7
39300	Биет бус хөрөнгө	18,747.0	19,086.2	19,600.2	339.1	514.0	101.8	102.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,085.0	6,424.2	5,256.5	339.2	(1,167.7)	105.6	81.8
3	НИЙТ ХӨРӨНГӨ	92,979.5	106,710.5	122,238.1	13,731.0	15,527.6	114.8	114.6
4	Нийт өр төлбөр	53,194.7	55,194.2	57,724.0	1,999.5	2,529.8	103.8	104.6
41	Богино хугацаат өр төлбөр	8,631.7	12,747.7	13,317.6	4,116.0	570.0	147.7	104.5
41100	Богино хугацаат үнэт цаас	15.6	512.8	10.0	497.2	(502.8)	3292.4	2.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	2,374.0	3,199.2	3,653.4	825.3	454.2	134.8	114.2
41300	Өглөг	3,872.4	5,790.6	6,639.7	1,918.1	849.2	149.5	114.7
41400	Урьдчилж орсон орлого	2,369.7	3,245.1	3,014.5	875.3	(230.6)	136.9	92.9
42	Урт хугацаат өр төлбөр	44,563.0	42,446.5	44,406.4	(2,116.5)	1,959.9	95.3	104.6
42100	Урт хугацаат үнэт цаас	16,855.3	13,596.0	15,560.0	(3,259.3)	1,964.0	80.7	114.4
42200	Урт хугацаат зээл	27,707.7	28,850.5	28,846.4	1,142.8	(4.2)	104.1	100.0
5	Цэвэр хөрөнгө, өмч	39,784.8	51,516.3	64,514.1	11,731.5	12,997.7	129.5	125.2
51	Засгийн газрын хувь оролцоо	39,769.4	51,500.9	64,498.6	11,731.5	12,997.7	129.5	125.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,744.0	8,029.2	7,867.8	285.2	(161.4)	103.7	98.0
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,077.9)	7,962.3	20,063.7	10,040.2	12,101.5	-383.2	252.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,463.2	7,444.3	7,510.1	(18.9)	65.8	99.7	100.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	164.9	149.9	154.7	(15.1)	4.8	90.9	103.2
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(0.0)	0.2	(0.0)	0.3		-595.0
52	Хяналтын бус хувь оролцоо	15.5	15.5	15.5	-	-	100.0	100.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ	92,979.5	106,710.5	122,238.1	13,731.0	15,527.6	114.8	114.6

Хавсралт 2. Засгийн газрын 2022-2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хийсэн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, дүнд эзлэх хувиар

Код	Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Бүтцийн шинжилгээ		
					2022	2023	2022
1	Эргэлтийн хөрөнгө	29,085.9	39,419.3	49,372.9	31.3	36.9	40.4
31	Мөнгөн хөрөнгө	6,636.7	12,090.9	14,545.8	7.1	11.3	11.9
32	Богино хугацаат хөрөнгө оруулалт	451.5	418.9	1,842.3	0.5	0.4	1.5
33	Авлага	6,333.8	6,445.2	6,811.7	6.8	6.0	5.6
34	Урьдчилгаа	3,614.5	5,137.6	5,891.6	3.9	4.8	4.8
35	Бараа материал	3,274.6	3,652.0	4,262.4	3.5	3.4	3.5
36	Нөөцийн бараа	210.6	210.1	262.2	0.2	0.2	0.2
360	Бусад эргэлтийн хөрөнгө	8,564.2	11,464.6	15,756.9	9.2	10.7	12.9
2	Эргэлтийн бус хөрөнгө	63,893.6	67,291.2	72,865.1	68.7	63.1	59.6
37	Урт хугацаат хөрөнгө оруулалт	11,558.5	11,769.9	13,292.0	12.4	11.0	10.9
37100	Урт хугацаат хадгаламж	56.9	60.0	58.0	0.1	0.1	0.0
37200	Үнэт цаас	3,506.3	3,270.0	2,660.0	3.8	3.1	2.2
37300	Урт хугацаат зээл	7,995.3	8,439.8	10,574.1	8.6	7.9	8.7
39	Үндсэн хөрөнгө	52,335.1	55,521.4	59,573.1	56.3	52.0	48.7
39100	Газар	59.8	46.0	46.1	0.1	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	27,443.2	29,965.0	34,670.4	29.5	28.1	28.4
39300	Биет бус хөрөнгө	18,747.0	19,086.2	19,600.2	20.2	17.9	16.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,085.0	6,424.2	5,256.5	6.5	6.0	4.3
3	НИЙТ ХӨРӨНГӨ	92,979.5	106,710.5	122,238.1	100.0	100.0	100.0
4	Нийт өр төлбөр	53,194.7	55,194.2	57,724.0	57.2	51.7	47.2
41	Богино хугацаат өр төлбөр	8,631.7	12,747.7	13,317.6	9.3	11.9	10.9
41100	Богино хугацаат үнэт цаас	15.6	512.8	10.0	0.0	0.5	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	2,374.0	3,199.2	3,653.4	2.6	3.0	3.0
41300	Өглөг	3,872.4	5,790.6	6,639.7	4.2	5.4	5.4
41400	Урьдчилж орсон орлого	2,369.7	3,245.1	3,014.5	2.5	3.0	2.5
42	Урт хугацаат өр төлбөр	44,563.0	42,446.5	44,406.4	47.9	39.8	36.3
42100	Урт хугацаат үнэт цаас	16,855.3	13,596.0	15,560.0	18.1	12.7	12.7
42200	Урт хугацаат зээл	27,707.7	28,850.5	28,846.4	29.8	27.0	23.6
5	Цэвэр хөрөнгө, өмч	39,784.8	51,516.3	64,514.1	42.8	48.3	52.8
51	Засгийн газрын хувь оролцоо	39,769.4	51,500.9	64,498.6	42.8	48.3	52.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,744.0	8,029.2	7,867.8	8.3	7.5	6.4
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,077.9)	7,962.3	20,063.7	(2.2)	7.5	16.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,463.2	7,444.3	7,510.1	8.0	7.0	6.1
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	164.9	149.9	154.7	0.2	0.1	0.1
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(0.0)	0.2	-	(0.0)	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо	15.5	15.5	15.5	0.0	0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ	92,979.5	106,710.5	122,238.1	100.0	100.0	100.0

Хавсралт 3. Засгийн газрын 2022-2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь үйл ажиллагааны орлого, зарлагад хийсэн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, дүнд эзлэх хувиар

Тайлангийн үзүүлэлт	2022	2023	2024	Бүтцийн шинжилгээ		
				2022	2023	2022
Үйл ажиллагааны орлого	31,213.3	42,806.6	56,004.7	100.0	100.0	100.0
<i>Татварын орлого</i>	<i>16,959.5</i>	<i>22,517.7</i>	<i>28,609.9</i>	<i>54.3</i>	<i>52.6</i>	<i>51.1</i>
Орлогын албан татвар	3,847.3	5,928.7	9,114.9	12.3	13.9	16.3
ХХОАТ	1,363.5	1,885.1	2,630.4	4.4	4.4	4.7
ХХОАТ-ын буцаан олголт	(51.1)	(64.5)	(78.9)	(0.2)	(0.2)	(0.1)
ААНОАТ	2,535.0	4,108.2	6,563.4	8.1	9.6	11.7
НДШ-ийн орлого	3,215.2	4,184.4	4,774.3	10.3	9.8	8.5
Хөрөнгийн албан татвар	237.6	394.9	459.5	0.8	0.9	0.8
НӨАТ	3,946.2	4,791.4	5,843.6	12.6	11.2	10.4
Онцгой албан татвар	847.8	790.1	1,098.2	2.7	1.8	2.0
Тусгай зориулалтын орлого	19.4	21.6	26.4	0.1	0.1	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	1,255.5	1,470.7	1,792.6	4.0	3.4	3.2
Бусад татвар, төлбөр, хураамж	3,590.5	4,935.9	5,500.3	11.5	11.5	9.8
<i>Татварын бус орлого</i>	<i>13,771.8</i>	<i>20,107.5</i>	<i>26,801.3</i>	<i>44.1</i>	<i>47.0</i>	<i>47.9</i>
Нийтлэг татварын бус орлого	13,336.4	19,712.1	26,054.4	42.7	46.0	46.5
Хөрөнгийн орлого	6.1	9.9	172.4	0.0	0.0	0.3
Тусламжийн орлого	429.3	378.7	555.8	1.4	0.9	1.0
Зээлийн орлого	-	6.8	18.9	-	0.0	0.0
<i>Тусламж, санхүүжилтийн орлого</i>	<i>482.0</i>	<i>181.5</i>	<i>593.5</i>	<i>1.5</i>	<i>0.4</i>	<i>1.1</i>
Үйл ажиллагааны зарлага	22,393.8	28,870.9	35,164.3	100.0	100.0	100.0
<i>Урсгал зардал</i>	<i>22,368.9</i>	<i>28,828.5</i>	<i>35,088.3</i>	<i>99.9</i>	<i>99.9</i>	<i>99.8</i>
<i>Бараа, ажил үйлчилгээний зардал</i>	<i>15,331.8</i>	<i>19,267.9</i>	<i>23,707.9</i>	<i>68.5</i>	<i>66.7</i>	<i>67.4</i>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,721.1	4,981.1	7,077.3	16.6	17.3	20.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	404.8	533.9	744.2	1.8	1.8	2.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	434.3	511.4	592.5	1.9	1.8	1.7
Хангамж, бараа материалын зардал	579.3	756.4	967.9	2.6	2.6	2.8
Нормативт зардал	668.9	709.8	807.2	3.0	2.5	2.3
Эд хогшил, урсгал засварын зардал	223.9	175.2	203.4	1.0	0.6	0.6
Томилолт, зочны зардал	81.9	114.8	148.9	0.4	0.4	0.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,126.4	8,450.2	9,239.3	22.9	29.3	26.3
Бараа үйлчилгээний бусад зардал	4,091.3	3,035.1	3,927.3	18.3	10.5	11.2
<i>Хүү</i>	<i>1,169.4</i>	<i>1,629.9</i>	<i>1,763.7</i>	<i>5.2</i>	<i>5.6</i>	<i>5.0</i>
<i>Татаас</i>	<i>1,046.5</i>	<i>657.4</i>	<i>827.4</i>	<i>4.7</i>	<i>2.3</i>	<i>2.4</i>
<i>Урсгал шилжүүлэг</i>	<i>4,821.2</i>	<i>7,273.2</i>	<i>8,789.3</i>	<i>21.5</i>	<i>25.2</i>	<i>25.0</i>
<i>Хөрөнгийн зардал</i>	<i>24.9</i>	<i>42.4</i>	<i>76.0</i>	<i>0.1</i>	<i>0.1</i>	<i>0.2</i>